

ЗОРИЛГО НАГДСАН ШИЙДЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-ХӨГЖЛИЙН ГАРЦ

2016 ОНЫ 10 САРЫН 26-НЫ ӨДӨР
ТӨРИЙН ОРДНЫ ИХ ТАНХИМ

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД:



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗОРИЛГО

Монгол Улсын санхүүгийн зах зээлд урт хугацааны санхүүжилтийн тогтолцоо харахан бүрдэж чадаагүй байгаа нь иргэд, аж ахуйн нэгжүүд өндөр өртөгтэй, богино хугацаатай банкны зээлийн эх үүсвэрийг ашиглахад хүргэж байна. Энэ нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, санхүүгийн салбарын зохистой бүтцийг бий болгох, бизнесийн байгууллагууд урт хугацааны хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Тиймээс олон тулгуурт санхүүгийн тогтолцоог төлөвшүүлж, хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгох, системийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна.

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид нэгдэн, зах зээлд тулгамдаж буй асуудлуудаа тодорхойлох, өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулахад хөрөнгийн зах зээлийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, ач холбогдлыг таниулан сурталчлах, цаашид авч хэрэгжүүлбэл зохих бодлогын санал дүгнэлтүүдийг нэгтгэн, УИХ, Засгийн газар, төрийн холбогдох байгууллагуудад хүргүүлж, урт хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгуулахад энэхүү хэлэлцүүлгийн зорилго оршино.



НЭГ ЗОРИЛГО - НЭГДСЭН ШИЙДЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ


Хэзээ: 2016.10.26 @ 9:00-15:00

Хаана: Төрийн ордны "Их танхим"

Эхлэх	Дуусах	Сэдэв	Илтгэгч
8:00	9:00	Бүртгэл	
9:00	9:10	Нээлтийн үг	Монгол улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат
9:10	9:20	Нээлтийн үг	УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Тэрбишдагва
9:20	9:30	Нээлтийн үг	Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн
Нэгдүгээр хэсэг: Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах			
9:30	9:55	Илтгэл: Судалгааны тайлан - Монголын хөрөнгийн зах зээлийг хөрөнгө оруулагчид хэрхэн дүгнэж байна вэ?	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны УЗ-ийн дарга Б.Өлзийбаяр
9:55	10:20	Илтгэл: Төрийн өмч хувьчлалд оролцсон хөрөнгө оруулагчийн туршлага, цаашид анхаарах зүйлүүд	"Ард санхүүгийн нэгдэл" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг
Хэлэлцүүлэг: Хөрөнгө оруулалтын татах боломж, шийдлүүд			
10:20	11:10	Модератор: Э.Лхагва - Монгол телевизийн мэдээний албаны ерөнхий продюсер Панел: Н.Номтойбаяр - УИХ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Бум-Эрдэнэ - Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Энхбаяр - Ерөнхий сайдын ахлах зөвлөх Nick Cousyn - Гадаадын хөрөнгө оруулагч Б.Батбаяр - Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг - "Ард санхүүгийн нэгдэл" ХХК-ийн гүйцэтгэх захирал Х.Алтай - "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал	
11:10	11:30	Завсарлага	
Хоёрдугаар хэсэг: Хөрөнгийн зах зээлийн хөгжил ба шинэ бүтээгдэхүүн			
11:30	11:55	Илтгэл: Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах ач холбогдол, асуудал ба шийдэл	Э.Мөнхсайхан - "Ремикон" ХК-ийн ТУЗ-ийн дарга
11:55	12:20	Илтгэл: Шинэ бүтээгдэхүүн бий болгох талаар Японы туршлага болон Монголын хөрөнгийн зах зээлийн арилжааг идэвхжүүлэх	Кандагийн Олон улс судлалын их сургуулийн профессор, Токиогийн хөрөнгийн биржийн Азийн бизнесийг хариуцсан ахлах стратеги асан Проф. Сейжи Адачи
12:20	13:00	Хэлэлцүүлэг: Дотоодын эдийн засгийн хөгжилд хөрөнгийн зах зээлийн ач холбогдол	
13:00	13:50	Модератор: Ч.Болортуяа - Ikon.mn сайтын ерөнхий редактор Панел: Т.Цэрэнбадрал - Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын дарга Ц.Ням-Осор - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Лхагважав - Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Г.Батцэнгэл - "Энержи ресурс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Мөнхсайхан - "Ремикон" ХК-ийн ТУЗ-ийн дарга С.Адачи - Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төслийн зөвлөх С.Даваасамбуу - "Монголын үнэт цаасны бирж" ХХК-ийн гүйцэтгэх захирал	
13:50	14:10	Оролцогч байгууллагууд Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээ	МУЦАЭХ, МХБ, МУЦБ, ҮЦТХТ, АТТ
14:10	14:25	Зөвлөмж гаргах	
14:25	14:35	Хаалт	МУЦАЭХ-ны УЗ-ийн дарга Б.Өлзийбаяр
14:35	15:35	Үдийн хоол	

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2016 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТОЙМ

Дүрслэл 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компани

№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/	№	Үнэт цаасны нэр	Үнэлгээ /тэрбум төгрөг/
1	АПУ	312.66	16	ТАЛХ ЧИХЭР	18.98
2	МИК ХОЛДИНГ	261.77	17	ДАРХАН НЭХИЙ	18.24
3	БАГАНУУР	81.80	18	БЭРХ УУЛ	17.63
4	ТАВАН ТОЛГОЙ	75.31	19	ХАЙ БИ ОЙЛ	16.89
5	ГОВЬ	63.97	20	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	16.08
6	СҮҮ	52.41	21	МАТЕРИАЛИМПЕКС	12.33
7	ШИВЭЭ ОВОО	38.58	22	ГЕРМЕС ЦЕНТР	11.00
8	ШАРЫН ГОЛ	38.37	23	АТАР-ӨРГӨӨ	10.80
9	БИ ДИ СЕК	31.11	24	СИЛИКАТ	10.43
10	МОНГОЛ ШУУДАН ХК	28.88	25	МАХИМПЕКС	10.07
11	ГУТАЛ	26.71	26	ЖЕНКО ТУР БЮРО	7.00
12	МОНГОЛ СЕКЮРИТИЭС	26.64	27	АРИГ ГАЛ	6.96
13	ТАХЬ-КО	22.61	28	МОНГОЛ ШИЛТГЭЭН	6.50
14	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	20.44	29	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	6.17
15	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	19.11	30	ХӨХ ГАН	5.98


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 2. ТОП-20 индекс



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 3. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 2. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	СЗХ	"Монголын хөрөнгийн бирж" ХК	"ҮЦТТТХТ" ХХК
Төрийн өмчит	32	21	22
Төрийн өмчийн оролцоотой	10	16	15
Орон нутгийн оролцоотой	15	-	8
Хувийн өмчит	243	199	276
Нийт	300	236	321

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 3. Ногдол ашиг тараасан хувьцаат компани

№	ХК-ийн нэр	Нийт ҮЦ-ын тоо ширхэг	Нэгж хувьцаанд тараасан	ХЭ-ийн тоо	ҮЦ-ны тоо ширхэг	Мөнгөн дүн
1	"Адуунчулуун" ХК	3,151,304	90.00	1,176	392,534	35,328,060.00
2	"Тахь-Ко" ХК	1,189,983	97.20	624	1,189,983	115,666,347.60
3	"МИК холдинг" ХК	20,709,320	217.08	104	20,709,320	4,505,739,518.52
4	"Атар-Өргөө" ХК	174,136	270.00	351	13,848	3,738,960.00
5	"АПУ" ХК	74,287,700	63.00	3,075	5,360,899	337,736,637.00
6	"Могойн гол" ХК	829,622	4.50	952	406,515	1,829,317.50
	Нийт			6,282	28,073,099	5,000,038,840.62

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 4. Зохицуулалттай этгээдийн тоо

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
3	Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын үйлчилгээ үзүүлэх	(1)
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	12
5	Брокер, дилер	62
6	Кастодиан банк	3
7	Андеррайтер /давхардсан тоогоор/	26
8	Хөрөнгө оруулалтын зөвлөх /давхардсан тоогоор/	15
	Нийт	81
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	37
11	Аудитын компани	44
12	Үнэлгээний компани	20
13	Хуулийн компани	20


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 5. Үнэт цаасны арилжааны үзүүлэлт


Арилжааны үзүүлэлтүүд	2015 оны 2-р улирал	2016 оны 2-р улирал
Үнэт цаасны тоо ширхэг /сая ширхэг/	19.3	47.9
Нийт үнийн дүн /тэрбум төгрөг/	290.5	98.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 4. Хувьцааны арилжаа




Дүрслэл 5. Шинээр болон нэмж үнэт цаас гаргагчдын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 6. ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 7. Нийт үнэт цаасны арилжааны бүтэц /хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 8. ҮЦТХТ-д нээгдсэн дансны тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дүрслэл 9. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Санхүүгийн зохицуулах хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу 2006 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өөрийн үйл ажиллагааныхаа талаар жил тутам Улсын Их Хуралд тайлагнадаг, түүний харьяа байгууллага юм.

Тус Хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй бөгөөд хорооны зохицуулалтанд банкнаас бусад санхүүгийн салбар буюу үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбар тус тус хамрагдаж байна.

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО /Өөрийгөө зохицуулах байгууллага/



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын санаачилгаар 1995 онд байгуулагдаж, түүнээс хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2015 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу үнэт цаасны зах зээл дээрх анхны "Өөрийгөө зохицуулах байгууллага" /ӨЗБ/ болсон юм.

Ингэснээр тус Холбоо нь үнэт цаасны зах зээл дээрх мэргэжлийн оролцогч байгууллагуудын албан ёс гишүүнчлэлтэй болж, зах зээлийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг бий болгох чиглэлд анхааран ажиллаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК



Монголын хөрөнгийн бирж нь 1991 онд байгуулагдаж, санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэгтэй үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Өнгөрсөн 25 жилийн хугацаандаа Монголын хөрөнгийн бирж нь нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүгийн зуучлалын үйлчилгээг үзүүлж, дотоодын аж ахуйн нэгжүүдэд үнэт цаас гаргах замаар Монголын хөрөнгийн зах зээлээс 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийг босгох боломж бүрдүүлж, олон улсын стандартад нийцсэн хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг бий болгож, хууль эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулсан юм.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ



Японы улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-аас Монголын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төслийг 2014 оноос Санхүүгийн зохицуулах хороон дээр хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд хөрөнгийн зах зээл дэх зохицуулалтын байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллагуудын чадавхийг бэхжүүлснээр хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, улмаар анхдагч зах зээлд хувьцаа гаргах, давхар бүртгэлийн орчинг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлж байна. Мөн хөрөнгийн зах зээлийг бэхжүүлэх бодлогын зөвлөлийг байгуулах, Хороонд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын үзэл баримтлалын баримт бичиг, судалгааг боловсруулах, анхдагч зах зээлээс хөрөнгө татахад нь компаниудад зөвлөгөө өгөх, давхар бүртгэлийг дэмжих, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг ажлуудыг хийхээр зорин ажиллаж байна.